

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ УДИРДЛАГААС ХАНГАЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Д.БУЛГАН

Хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа

Д.НАРАНБААТАР

Магистр (MML), судлаач

D.BULGAN

Doctor of Law (Ph.D), police lieutenant colone

D. NARANBAATAR

Master (MML), researcher

Товчлол: Улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн хямрал, гэмт хэрэг, зөрчлийн гаралт жил бүр нэмэгдэж цагдаагийн алба хаагчийн үүрэг, хариуцлага, ажлын ачаалал, ихсэж байна. Иймд цагдаагийн алба хаагчийн цалин хөлс, эдийн засгийн баталгааг нэмэгдүүлэх, түүний эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг судалж, сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэхүү сэдвээр цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгааны өнөөгийн байдлыг тодорхойлохын тулд 406 алба хаагчаас судалгаа авч, хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, дүн шинжилгээ хийлээ.

Abstract: The crime rate is increasing every year and the workload of police officers is increasing. Therefore, there is a need to increase the salaries and economic guarantees of police officers, to study and improve the implementation of its legal regulations, and to bring them in line with international standards. In order to determine the current state of economic security of police officers on this topic, a survey of 406 police officers was conducted to study and analyze the implementation of legislation.

Түлхүүр үг. Цагдаагийн алба хаагч, цагдаагийн байгууллага, эрх зүйн байдал, баталгаа, эдийн засгийн баталгаа.

Key word. Police officers, police, legal status, guarantees, economic guarantees.

Удиртгал. Цагдаагийн алба хаагч нь цагдаагийн байгууллагаас төрийн өмнө хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тангараг өргөсөн төрийн тусгай албан хаагч юм. Цагдаагийн алба хаагч албан үүргээ биелүүлэхийн тулд тодорхой эрх эдэлж, эдийн засгийн болон нийгмийн баталгаагаар хангагдах ёстой бөгөөд энэхүү баталгааг нь төр хариуцдаг.

“Төрийн албаны тухай хуульд “төрийн албан хаагч” гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ¹” гэж заасан.

Цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгааг “Цагдаагийн албаны тухай хууль”², Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”³, “Цагдаагийн ерөнхий газрын

¹Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2. Төрийн мэдээлэл №01, 2018 он.

²Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл №08, 2017 он.

³Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. Засгийн газрын 2020 оны 141

дүгээр тогтоолын хавсралт. Хөтөлбөрийн 3.2.4-т “Байгууллагын аюулгүй байдлыг хангах, алба хаагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүй, эдийн засаг, нийгмийн баталгааг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ”, 3.2.4.1. цагдаагийн алба хаагчийн цалинг бусад

цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-т тусгаж, хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа хэдий ч түүний хэрэгжилт хэр үр дүнтэй байгааг судалж, тогтоох хэрэгцээ шаардлага байсаар байна. Тиймээс энэхүү сэдвийг дараах үндэслэлээр судаллаа. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал их, цалин бага байгаа нь хэд хэдэн судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын 14 дэх илтгэлд “... нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагч 7 хоногийн 6 өдөр буюу хамгийн багадаа сард 192 цаг, жилд 2112 цаг ажиллаж, ... жилд хамгийн багадаа 352 цаг илүү цаг ажилладаг⁴ талаар дурдагдсан.Мөн “Төрийн албаны тухай

хууль”-ийн 57 дугаар зүйлийн 57.1-т “төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно” гэж заасан. Гэтэл цагдаагийн алба хаагчийн авч буй цалин хөлс нь хийж гүйцэтгэж буй ажилтай нь харьцуулахад хангалттай эсэх, эдийн засаг баталгаа нь хангагддаг эсэх нь эргэлзээтэй байна.

2. “Цагдаагийн албаны тухай хууль” 2017 онд шинэчлэн батлагдсан бөгөөд цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгааг тухайлан тусгаж, өмнөх хуулиудаас үр нөлөөг нь дээшлүүлэхэд чиглэсэн. Хуульд эдийн засгийн баталгааг хэрхэн тусгасныг дараах хүснэгтээр харьцуулан үзье.

Хүснэгт №01. Цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгаа

№	ЦАТХ /2017/	ТАТХ /2017/
1.	83.1.Цагдаагийн алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан баталгаагаар хангагдана.	61.1.Төрийн албан хаагч дараахьнийтлэг баталгаагаар хангагдана:
2.	87 дугаар зүйл. Эдийн засгийн баталгаа 87.2.Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн, ... замын зардлыг ... 2 жилд нэг удаа олгоно. 87.3.Цагдаагийн алба хаагч шилжин ажиллах ... тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно.	61.1.1.албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах;
3.	87.4.Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдлын үед болон голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.	61.1.9.ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох;
4.	87.5.Цагдаагийн байгууллага алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед ... хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно.	

Хүснэгтээс харахад шинэчлэн батлагдсан хуульд цагдаагийн алба хаагчийн баталгааг төрөлжүүлэн тусгасан бөгөөд эдийн засгийн баталгаа гэсэн нэр томъёог шинээр хэрэглэсэн бөгөөд өмнөх хуультай харьцуулахад нэмэгдсэн зохицуулалт байхгүй, эдийн засгийн баталгааг нэр төдий, хангалттай бус,

зохицуулалт дутмаг байгаа нь харагдаж байна. Тухайлбал, нийтийг хамарсан арга хэмжээ, бүх нийтийн баяр, амралтын өдөр, өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед ажилласан цагийн хөлсийг авах зохицуулалт байхгүй байна. Практикт цагдаагийн алба хаагчдын цалинг бодохдоо тухайлбал, цагаан сар,

хуулийн байгууллагуудын жишигт нийцүүлэн үе шаттайгаар нэмэгдүүлэх.

⁴Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2020 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ.<https://police.gov.mn/as/static>.

наадмын хамгаалалтад ажилласан ч бүх нийтийн амралтын өдөр тул цалинг нь өгдөггүй. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал их, түүнд тохисон цалин хөлс авах эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

3. Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хямрал, инфляц нэмэгдэж буй энэ цаг үед цагдаагийн алба хаагчийн ажлыг оновчтой хуваарилж, цалин хөлсийг нэмэгдүүлэх, эдийн засгийн баталгааг сайжруулахарга замыг тодорхойлох хэрэгцээ шаардлага байсаар байна. Тиймээс энэхүү өгүүлэгийн зорилго нь цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгаа болох цалин хөлсний өнөөгийн байдлыг судалж, тодорхойлохоор алба хаагчдаас судалгаа авч, дүн шинжилгээ хийж,

цаашид анхаарах, сайжруулах арга замыг эрэлхийлэхэд чиглэгдсэн.

Нэг. Цагдаагийн алба хаагчдаас авсан судалгаа.

Судалгаанд нийт 406 алба хаагч оролцсоноос эрэгтэй 378, эмэгтэй 27 оролцсон. Алба хаагчдыг нас болон ажилласан жилээр нь авч үзвэл насны хувьд 18-24 насны 38, 25-30 насны 94, 31-36 насны 166, 37-42 насны 73, 43-48 насны 22, 49-54 насны 7, 55 дээш насны 1, алба хаагч нар судалгаанд оролцсон. Алба хаагчдын 74,0 хувь нь 18-36 насны алба хаагч, 26 хувь нь 37-54 насны алба хаагч судалгаанд хамрагдсан.

Судалгааг хүснэгтээр харуулбал:


Хүснэгт № 20. Алба хаагчийн насны ангиллаар

	Үзүүлэлт	Давтамж	Хувь
Хүйс	18-24	38	10.4%
	25-30	94	23.5%
	31-36	166	41.5%
	37-42	73	17.1%
	43-48	22	5%
	49-54	7	2.1%
	55-аас дээш	1	0.3%
Ажилласан жил	1-5	103	25.6%
	6-10	126	30.9%
	11-15	94	23.8%
	16-20	56	12.9%
	20 дээш жил	26	6.8%
Ажиллаж буй газар	Орон нутаг	241	59%
	БЗДЦГ	26	6%
	СХДЦГ	32	8%
	ХУДЦГ	31	8%
	БГДЦГ	11	3%
	ЧДЦГ	6	2%
	СБДЦГ	14	3%
	Багануур дүүргийн ЦГ	13	3%
	Багахангай дүүргийн цагдаагийн газар	6	2%
	Налайх дүүргийн ЦГ	26	6%
	Нийт	406	100%

Алба хаагч нарын дийлэнх хувь буюу 74.4 хувь нь 6-20 жил ажилласан алба хаагч нар судалгаанд хамрагдсан нь судалгааны үр дүн бодитой байх магадлал өндөр харагдаж байна. Судалгаанд 406 алба хаагчийн 59 хувь нь хөдөө, орон нутагт, үлдсэн 41 хувь нь Улаанбаатар хотод үүрэг гүйцэтгэж буй алба хаагч оролцжээ.

Цагдаагийн алба хаагчийн цалин бусад төрийн алба хаагчийн цалинтай харьцуулахад хангалттай юу? гэж асуухад дараах үр дүн гарсан.

Зураг № 01. Төрийн бусад алба хаагчидтай харьцуулсан байдал.




Цагдаагийн алба хаагчийн цалинг бусад төрийн байгууллагын алба хаагчийн цалинтай харьцуулах ямар түвшинд байгааг тодорхойлохоор асуулга авахад судалгаанд оролцогчдын 341 алба хаагч буюу 83,9 хувь нь шүүгчтэй харьцуулахад “маш муу”, 48 алба хаагч буюу 1.9 хувь нь “муу”, 4 алба хаагч буюу 1 хувь нь “адилхан” гэж хариулсан. Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчидтай харьцуулахад хамгийн бага гэж 153 алба хаагч, муу гэж 118 алба хаагч тус тус хариулсан. Эндээс харахад цагдаагийн алба

хаагчийн цалин бусад төрийн байгууллагын алба хаагчийн цалингаас маш бага байгааг цагдаагийн алба хаагчид бүгд хүлээн зөвшөөрч байна. Дээрх төрийн бусад алба хаагч тухайлбал, адил чиг үүрэг гүйцэтгэдэг АТГ-ын мөрдөгч, шүүгч, прокурор цагдаагийн алба хаагчаас 3-5 дахин цалинтай байна.

Цагдаагийн алба хаагчийн цалин хийж буй ажилтай нь харьцуулж үзэхэд тохирсон эсэх талаар асуухад дараах үр дүн гаргасан байна.

Зураг №02. ЦАХ-ын хийж буй ажил ба цалингийн харьцуулалт



Энэхүү графикаас харахад цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал их, цалин бага гэж 94% хувь буюу 380 алба хаагч хариулжээ. Энэ нь хийж буй ажилтай нь харьцуулахад цалин бага авдаг болох нь харагдаж байна.

Мөн цагдаагийн алба хаагчид илүү цагаар ажилласан ажилтны илүү цагийн мөнгийг олгодог уу? гэсэн асуултад 387 алба хаагч огт өгдөггүй, 13 алба хаагч заримдаа, дийлэнхдээ өгдөг гэж 5 алба хаагч хариулсан.

хандлага өөрчлөгдөж амьдралын хэрэгцээ шаардлага нь тодорхой хэмжээг хангагдах нөхцөл бүрдэнэ.

Цагдаагийн алба хаагчдаас Та зээлтэй юу? Та зээлээ төлөөд үлдсэн цалин чинь таны амьжиргаанд хүрч байна уу? гэсэн асуултад дараах үр дүн гарчээ.

Зургаас харахад зээлгүй гэж 4 хувь, зээлтэй, цалин хүрдэггүй гэж 88 хувь, зээлтэй, цалин хүрдэг гэж 8 хувь нь тус тус хариулжээ, Энэ нь авч байгаа


Алба хаагчид зээлтэй эсэх, цалин хүрэлцдэг эсэх.



Долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол цалин авдаг уу? гэсэн асуултад өгдөггүй гэж 378 алба хаагч, заримдаа гэж 19 алба хаагч хариулжээ. Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол цалин авч байсан уу? гэсэн асуултад өгдөггүй гэж 379 алба хаагч, заримдаа гэж 16 алба хаагч хариулжээ. Шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол цалин авч байсан уу? гэсэн асуултад өгдөггүй гэж 370 алба хаагч, заримдаа гэж 28 алба хаагч тус тус хариулжээ. Эндээс харахад судалгаанд оролцогчдын 90 дээш хувь нь цалин бага, илүү цагаар ажиллуулсан хөлсийг өгдөггүй гэж хариулжээ. Тиймээс “Хөдөлмөрийн тухай хууль”-д заасан үндэслэл журмын дагуу алба хаагч нартаа цалин, цалингийн нэмэгдэл, нөхөн өгөх асуудлыг судлан үзэж, тодорхой төрлийн ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Хэрэв алба хаагчид илүү цаг ажилласан бол илүү цагийн хөлсийг авах нь цагдаагийн алба хаагчийн сэтгэл зүй, албандаа хандах

цалин хөлс амьдралын хэрэгцээ шаардлагад хүрэлцэхгүй болох нь харагдаж байна.

Зураг №04. Цалингийн хүртээмж



Цагдаагийн алба хаагчийн сарын цалин таны амьдралын хэрэгцээнд хүрч байна уу? гэсэн асуултад дараах үр дүн гарчээ. Боловсрол эзэмшихэд огт хүрэлцдэггүй гэж 252, дутуу-хүрэлцдэггүй гэж 108, дунд зэрэг гэж 39, дийлэнхдээ хүрэлцдэг гэж 4 алба хаагч тус тус хариулжээ. Харин эрүүл мэндэд огт хүрэлцдэггүй гэж 239, дутуу -хүрэлцдэггүй гэж 36, дунд зэрэг 36, дийлэнхдээ хүрэлцдэг гэж 3 алба хаагч хариулжээ. Аялал, зугаалга(гадаад улс оронд аялах)-д огт хүрэлцдэггүй гэж 288, дутуу-хүрэлцдэггүй гэж 81, дунд зэрэг 26, дийлэнхдээ гэж 3 алба хаагч хариулжээ. Мөн өөрийн хэрэгцээнд ашиглах эд зүйлийг худалдан авахад огт



хүрэлцдэггүй гэж 181, дутуу, хүрэлцдэггүй гэж 153, дунд зэрэг гэж 58, дийлэнхдээ гэж 8 алба хаагч тус тус хариулжээ. Асуултыг нэгтгэн авч үзвэл боловсрол эзэмшихэд цалин нь огт хүрэлцдэггүй, дутуу-хүрэлцдэггүй гэж судалгаанд оролцогчдын 360 алба хаагч буюу 88,6 хувь нь амьдралын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагч амьдралын наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа нь авлига, хээл хахууль авах, албан тушаалын гэмт хэрэгт өртөх, цаашлаад байгууллагын дотоод аюулгүй байдалд эрсдэл учрах магадлалтай гэсэн үг юм.


Цагдаагийн алба хаагчийн цалингийн хэмжээ нь өнөөгийн нийгэмд авлига авах нөхцөлийг бүрдүүлдэг үү? гэсэн асуултад судалгаанд оролцсон 406 алба хаагчаас тийм гэж 159 алба хаагч буюу 40.1%, заримдаа гэж 73 алба хаагч буюу 18.4%, үгүй гэж 173 алба хаагч буюу 41.5% нь тус тус хариулжээ. Судалгааны дүнгээс харахад цагдаагийн алба хаагч заримдаа буюу тийм гэж 58.5 хувь нь

хариулсан нь албан тушаалаа урвуулан ашиглах, авлига, хээл хахуульд өртөх магадлал өндөр байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагчийн цалинг нэмэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Та цалингаас мөнгөн хуримтлал үүсгэж чадаж байна уу? гэсэн асуултад тийм гэж 6 алба хаагч буюу 2%, үгүй гэж 370 алба хаагч буюу 91%, заримдаа хадгалдаг гэж 29 алба хаагч буюу 7% нь тус тус хариулжээ. Энэ нь цагдаагийн алба хаагчид цалингаас цалингийн хуримтлал үүсгэх боломжгүй болох нь харагдаж байна.

Танд Цагдаагийн байгууллагаас алба хаагчийг хөнгөлөлттэй үнээр орон сууцаар хангах, түлээ, түлш болон бусад хөнгөлөлтийг хангалттай үзүүлж байна уу? гэсэн асуултад тийм гэж 16 алба хаагч буюу 4%, үгүй гэж 332 алба хаагч буюу 82%, заримдаа гэж 57 алба хаагч буюу 14% нь тус тус хариулсан байна. Цагдаагийн байгууллагын зүгээс цагдаагийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдэх тодорхой төрлийн ажил арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж чадахгүй байгаа нь энэхүү судалгаанаас харагдаж байна. Хөдөө орон нутагт ажиллаж байгаа алба хаагч нарт 5 жил тутамд 30 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал өгдөг. Үүний хэрэгжилтийг үнэлнэ үү? гэсэн асуултад нийт 385 алба хаагч хариулсан бөгөөд үүнээс 214 алба хаагч энэ урамшууллыг аваагүй, харин 84 алба хаагч буюу 22% хугацаанд нь авсан, авах гэсэн боловч өөр албан тушаалд шилжүүлсэн гэж 40 алба хаагч буюу 10%, төсөв санхүүтэй холбоотой авч байгаагүй гэж 3 алба хаагч буюу 1%, авсан боловч маш их удаж байж авсан гэж 32 алба хаагч буюу 8%, мөнгийг бүрэн гүйцэт бодож олгоогүй гэж 12 алба хаагч буюу 3% нь тус тус хариулсан.

Та цалингаасаа албан хэрэгцээнд мөнгө гаргаж ажилдаг уу? гэсэн асуултын хүрээнд та бензиний мөнгө гаргаж үүргээ гүйцэтгэдэг үү гэж асуухад огт мөнгө гаргадаггүй гэж 49, хааяа гаргадаг гэж 84, дунд зэрэг гэж 44, дийлэнхдээ гаргадаг гэж 91, дандаа гаргадаг гэж 82 алба хаагч тус тус хариулжээ.



гаргадаггүй гэж 35 алба хаагч, хааяа гаргадаг гэж 94 алба хаагч, дунд зэрэг гэж 101 алба хаагч, дийлэнхдээ гаргадаг гэж 74 алба хаагч, дандаа гаргадаг гэж 48 алба хаагч тус тус хариулжээ.

Хоолны зардал огт мөнгө гаргадаггүй гэж 30 алба хаагч, хааяа гаргадаг гэж 61 алба хаагч, дунд зэрэг гэж 59 алба хаагч, дийлэнхдээ гаргадаг гэж 94 алба хаагч, дандаа гаргадаг гэж 112 алба хаагч тус тус хариулжээ.

Тусгай хэрэгсэлд огт мөнгө гаргадаггүй гэж 62 алба хаагч, хааяа гаргадаг гэж 122 алба хаагч, дунд зэрэг гэж 81 алба хаагч, дийлэнхдээ гаргадаг гэж 49 алба хаагч, дандаа гаргадаг гэж 29 алба хаагч тус тус хариулжээ.

Бичиг хэрэгт огт мөнгө гаргадаггүй гэж 39 алба хаагч, хааяа гаргадаг гэж 96 алба хаагч, дунд зэрэг гэж 57 алба хаагч,

дийлэнхдээ гаргадаг гэж 86 алба хаагч, дандаа гаргадаг гэж 76 алба хаагч тус тус хариулжээ.

Албаны өрөө тасалгаа тохижуулахад огт мөнгө гаргадаггүй гэж 41 алба хаагч, хааяа гаргадаг гэж 97 алба хаагч, дунд зэрэг гэж 76 алба хаагч, дийлэнхдээ гаргадаг гэж 72, дандаа гаргадаг гэж 71 алба хаагч тус тус хариулжээ.

Хоёр. Цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгааны хэрэгжилт. Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь хэсэгт гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах¹ гэж заасан боловч өнөөдөр цагдаагийн алба хаагч хийж гүйцэтгэж байгаа ажилдаа тохирсон цалин авахгүй, өдөр бүр илүү цагаар ажиллаж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Мөн хуулийн 43, 84 дүгээр зүйлүүдэд ажлын долоо хоногт ажлын цаг 40-өөс илүүгүй, ажлындээдхязгаар нь 56 цаг, өдөрт ажиллах илүү цаг нь 4 цагаас илүүгүй, мөн хуулийн 87 дугаар зүйлийн 87.4-т “ажилтныг хоёр ээлжид дараалуулан ажиллуулахыг хориглоно”² гэж тус тус заасан. Эдгээр заалт нь цагдаагийн байгууллагад огт хэрэгжихгүй байгаа цагдаагийн алба хаагчидтай хийсэн ярилцлага, судалгаанаас харагдаж байна.

Мөрдөгч, хэсгийн байцаагч, эрүүгийн мөрдөгч, хэсгийн төлөөлөгч, хэв журмын офицер, жижүүрийн ахлах, зөрчлийн байцаагч, мэргэжилтэн гэх алба тушаалд ажиллаж байгаа алба хаагч өнөөдөр ТТ-9-ээр цалинждаг. Харин ахлах болон тасгийн дарга, хэсгийн дарга нар ТТ-11, ТТ-12 цалинжиж байна. Тэгтэл Онцгой байдлын байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер албан тушаал дээр үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа алба хаагчид ТТ-10,11, харин ахлах, дарга нар нь ТТ-13-15-аар цалинждаг. Тэгэхээр цагдаагийн алба хаагчийн цалингийн шатлал бусад төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчийн цалингаас 1-2 шатлалаар бага байна.

¹Хөдөлмөрийн тухай хууль. 42 дугаар зүйлийн 42.1.3. дахь хэсэг.

²Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.4. дэх хэсэг.

Мөн цагдаагийн байгууллагатай адилхан чиг үүрэг гүйцэтгэж хэрэг, зөрчил шалгаж, хуулийг хэрэгжүүлдэг прокурор, авлигатай тэмцэх газрын алба хаагч, ажилтан нар багадаа 2.500.000-3.000.000 хооронд цалин авч ажиллаж байна. Прокурорын байгууллагын прокурорын туслах, бичээч гэхэд сарын цалин нь 1.300.000 мянган төгрөгөөс эхэлдэг бол цагдаагийн байгууллагын офицерын цалин бүх нэмэгдэлтэйгээ 900.000 төгрөгөөс эхэлж байна. Эндээс харахад цагдаагийн алба хаагчид цалингаа хангалтгүй, бага гэж хэлэх нь зүй ёсны юм.

ЦЕГ-аас цагдаагийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөрийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 691 дүгээр тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр” батлагдан гарч 2011-2013 онд 2 үе шаттайгаар хэрэгжсэн³.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”⁴ батлагдсантай уялдуулан Цагдаагийн ерөнхий газрын дарга 2020 оны А/163 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт”-ийг баталж, анги, байгууллагуудад хүргүүлснээр 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн⁵.

Цагдаагийн байгууллагаас алба хаагчийнхаа эдийн засгийн баталгаа хангах чиглэлээр хийсэн ажлыг судлах зорилгоор ЦЕГ-ийн 2020, 2021 оны үйл ажиллагааны тайланг судлан үзэхэд дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, ажилтнуудаас 2021 онд албан

үүргээ гүйцэтгэх явцдаа зөрчлийн шинжтэй 9 үйлдэлд 9 алба хаагч, гэмт хэргийн шинжтэй 171 үйлдэлд 187 алба хаагч тус тус өртөж хохирсон⁶ байна. Дээрх алба хаагчийн нийгмийн асуудлыг хэрхэн шийдсэн талаар авч үзэхэд 4 алба хаагчид 4.7 сая, нас барсан 1 алба хаагчийн ар гэрт 16.0 сая төгрөг нийт 20.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон дүн мэдээ⁷ байна. Ингэхээр цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндийн баталгаагаар хангагдах асуудал төдийлөн сайн хэрэгжихгүй, нэр төдий асуудал хэвээр байна.

Мөн цагдаагийн байгууллагын хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд 34 нэгжийн 408 алба хаагч бэртэж гэмтсэн, гэмт халдлагад өртөж хохирсон бөгөөд үүнээс 394 алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа, 14 алба хаагч нь ажлын бус цагаар буюу албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй нөхцөл байдалд⁸ хохирчээ. Энэ нь хуульд зааснаар цагдаагийн алба хаагч бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалдаг боловч цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар заалт байхгүй байна.

Харин Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1. дэх хэсэгт цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа⁹ олгоно, мөн хуулийн 86.3. дахь хэсэгт цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар дараах нөхөх олговор, тусламж¹⁰ олгоно гэж тус тус заасан. Энэ хуулийн заалт цагдаагийн

³Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр, УБ, 2020он

⁴Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. <https://legalinfo.mn/mn/detail/15324>. 2022.03.22

⁵Цагдаа, дотоодынцэргийналбахаагч, ажилтныэрх,

хуульёсныашигсонирхлыгхамгаалаххөтөлбөр, төлөвлөгөө. <http://police.gov.mn/a/5358/> 2022.03.22

⁶Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны тайлан УБ, 2021он.

⁷ Мөн тэнд.

⁸Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр, УБ., 2020 он.

⁹Цагдаагийн албаны тухай хууль, 2017 он. [//legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74](http://legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74) 2022.03.22

¹⁰Цагдаагийн албаны тухай хууль, 2017 он. [//legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74](http://legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74) 2022.03.22

алба хаагчийн амь нас, эрүүл мэндийн баталгаа болж чадахгүй юм.

Цагдаагийн алба хаагчид урт хугацааны өндөр хүүтэй зээлд хамрагдаж орон сууцтай болж байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, өнөөдөр 1мкв байрны үнэ багадаа 1.500.000¹¹ мянган төгрөгөөс эхэлж байна гэж үзвэл алба хаагч хэрэгцээндээ 50 мкв байр зээлээр худалдан авахад 75.000.000 сая төгрөг худалдан авна. Алба хаагч байр авахын тулд урьдчилгаа гэж 20%-30% хувийг өөрийн төрсөн аав, ээж, ах, дүү, садан төрлөөсөө тусламж, зээл хэлбэрээр аваад банк, санхүүгийн байгууллагад ханддаг. Харин банк, санхүүгийн байгууллага алба хаагчдыг урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаатай жилийн 14%-аас 18% хувийн хүүтэй¹² зээлийг санал болгож орон сууцны зээлд хамруулдаг. Алба хаагч 50 мкв байр авахын тулд 52.500.000 төгрөгийг банк, санхүүгийн байгууллагаас зээлж аваад 15 жилийн дотор төлж дуусгах бөгөөд 15 жилд хамгийн багадаа 100.000.000 сая төгрөгийг хүү төлнө гэсэн үг. Төрийн алба хаагч өөрийн цалингаар байр орон сууц авъя гэж үзвэл төрийн алба хаагчийн дундаж цалин 1.070.000 төгрөг¹³. Тэгвэл алба хаагч 75.000.000 сая төгрөгийн үнэтэй 50 мкв орон сууцыг 5 жил 6 сарын хугацаанд гэр бүл болон өөрийн хэрэгцээнд нэг ч төгрөг зарцуулахгүй байж чадвал 50 мкв байр худалдан авахаар тооцоо судалгаа гарч байна.

Дүгнэлт

Цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгааг тодорхойлохоор 406 алба хаагчдаас судалгаа авч, зарим асуултын хүрээнд ярилцлага хийж, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг судалж үзлээ. Судалгаанаас барахад цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал их, цалин бага байгаа гэж судалгаанд оролцогчдын 94% нь хариулсан. Мөн цалин нь өөрийн амьдралд хүрэлцэхгүй, урамшуулал хангалттай биш гэж 84 хувь нь хариулсан нь цагдаагийн алба хаагчийн эдийн

засгийн баталгааг муу, хангалтгүй бөгөөд сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй гэж дүгнэхээр байна.

Цагдаагийн алба хаагчидтай адилхан чиг үүргийг хэрэгжүүлж буй прокурор, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын байгууллагын тангараг өргөсөн алба хаагчид нь 2-3 дахин их цалинтай бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын алба хаагчдаас албан тушаалын зэрэглэл 1-2 доогуур байгаа нь цалин, тэтгэвэр, тэтгэмж, урамшуулалд шууд нөлөөлж байна.

Санал

1. Цагдаагийн алба хаагчийн цалинг төрийн бусад хууль хэрэгжүүлдэг байгууллагын цалинтай нэг жишигт хүргэх;

2. Цагдаагийн алба хаагчийг бүх нийтээр амрах амралтын өдөр, нийтийг хамарсан арга хэмжээ, нийтийн эмх замбараагүй байдал, хүн малын гоц халдварт өвчин гарсан үед ажиллаж байгаа алба хаагчийн тухайн өдрийн цалинг 2 дахин нэмэгдүүлэх талаар хуульд тусгах;

3. Цагдаагийн алба хаагчдын эдийн засаг, нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн бие даасан хөтөлбөрийг боловсруулж, батлуулах;

4. Цагдаагийн алба хаагчдыг жилд онцгой гавьяа байгуулсан тохиолдолд 9-15 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгох. Энэ нь тодорхой шалгууртай байх бөгөөд журмаар нарийвчлан зохицуулах. Энэхүү шалгуурт:

- Хүний амь нас аварсан байх
- Онц их хэмжээний эд хөрөнгийг хамгаалсан байх
- Хүнд, ноцтой гэмт хэргийг илрүүлсэн байх г.м.

¹¹Шинэ орон сууцны үнэ ханшийн мэдээлэл 2022 оны 3-р сар.

<https://www.barilga.mn/n/12843/> и2022.03.24

¹²Зээлийн хүүгийн мэдээлэл.

<http://www.mongo.mn/product/2053>. 2022.03.28

¹³Төрийн алба хаагчийн цалинг нэгдүгээр сарын 1-нээс нэмнэ. <https://gogo.mn/r/l8e19> . 2022.03.28